

**“Монгол-Хятадын мөнгө санхүүгийн
хамтын ажиллагаа” анхдугаар форум
дээр ШУА-ийн Ерөнхийлөгч, академич
Б.Энхтүвшингийн хэлсэн үг**

Эрхэм хүндэт эрдэмтэд ээ

Хүндэт зочид оо,

Та бүхний өдрийн амгаланг айлтгая

Өнөөдөр бид Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны нэгэн чухал сэдэв болох мөнгө, банк, санхүүгийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэхээр хуран цуглараад байна. Манай Олон улс судлалын хүрээлэн, Хятадын Санхүү эдийн засгийн төв их сургуулийн Санхүүгийн сургуулийн санаачилгаар зохион байгуулж буй “МОНГОЛ-ХЯТАДЫН МӨНГӨ, САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА” анхдугаар форумын онцлог, ач холбогдлын талаар хэдэн үг хэлмээр байна. Юуны өмнө хоёр талын эрдэмтэд, мэргэжилтнүүд манай хоёр орон мөнгө, банк, санхүүгийн салбарт хэрхэн хамтран ажиллах талаар нүүр тулан хэлэлцэх, хамтран судалгаа явуулах ажил тулгамдсан асуудал болоод байна. Нийгэм, зах зээл ч үүнийг шаардаж байна. Хоёрдугаарт, Хятад улс бол мөнгө санхүүгийн асар их нөөц, потенциалтай хүчирхэг орон. Дэлхийн олон орон Хятадын зах зээлд гарах, тэндээс хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт татахыг хичээж байна. Тун саяхан Хятадын цахим худалдааны манлайлагч “Алибаба” групп Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргаснаар 25 тэрбум ам.долларыг төвлөрүүлээд байна. Энэ бол түүхэнд байгаагүй дээд амжилт, олон улсын хөрөнгийн зах зээл дээрх Хятадын “тэсрэлт” хэмээн хэвлэлийнхэн шуугиж байна. Тус компанийн хувьцаа Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр гарсан даруйд нэг минут ч хүрэхгүй хугацаанд 100 сая гаруй ширхэг арилжаалагджээ. Тус компанийн үнэлгээ одоо 223 тэрбум ам.долларт

хүрч, Facebook, Amazon, eBay-г ч давжээ. Гэхдээ ийм том зах зээл, мөнгө санхүүгийн асар их нөөцтэй том хөрштэйгээ манайх шиг жижиг орон хамтран ажиллахын тулд нэлээд анхаарал болгоомжтой байх хэрэгтэй гэдгийг манай салбар салбарын хүмүүс анхааруулж байгаа. Өөрөөр хэлбэл, боломж потенциалын зэрэгцээ аюул эрсдэлийн судалгааг сайн хийх хэрэгтэй гэсэн үг юм.

Гуравдугаарт, энэ жил Монгол-Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой, БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж, хоёр орны ерөнхийлөгч нар стратегийн иж бүрэн түншлэлийн харилцааг хөгжүүлэхээ зарласан түүхэн тэмдэглэлт жил болж өнгөрч байна. Энэ нь хорш зэргэлдээ манай хоёр улсын хувьд харилцан ашигтай, бие биенээ нөхөх замаар “хамтдаа хожих” зарчим дээр тулгуурласан бодлогыг хэрэгжүүлэх сайхан нөхцлийг бүрдүүлж өгөв. Хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өргөжин гүнзгийрч мөн эрчимжихийн хирээр судлаач, шинжээч, мэргэжилтнүүдийн судалгааны сэдэв ч мөн нарийсан, судалгаа шинжилгээний байгууллага, эрдэмтэн профессор та бүхний гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь мөн нэмэгдсээр байгаа юм. Ийм онцлог нөхцөл байдалд өнөөдрийн анхдугаар чуулган болж байна.

Нөгөөтэйгүүр хоёр орны харилцааны чиглэл, хамтын ажиллагааны үр дүн нь бидний хийх болон хийж буй судалгаа, урьдчилсан тооцооноос ихээхэн хамаарах билээ. Иймээс бид хамтран энэ чиглэлд ихээхэн чармайлт гарган хоёр улсын шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн идэвхжүүлэх нэн шаардлагатай байна. Бид мөн энэ талаар тодорхой амжилтанд хүрснийг тэмдэглэхэд таатай байна. Тухайлбал Монгол, Хятадын Шинжлэх Ухааны Академийн хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулагдан амжилттай хэрэгжиж байна. БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн туслах ноён Хао Шиюань Монголын ШУА-ийн хүндэт гишүүн болсон зэрэг юм. Цаашид бид үйл ажиллагаа, судалгааны чиглэлээ ойртуулан зохицуулж хоёр орны хамтын ажиллагааны амжилтын төлөө ажиллах болно. Өнөөдрийн энэ хурал ч бидний энэ зорилгод хүрэх нэг алхам юм.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье